



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОБЕГ-ЫН ХАРЬЯА АР ТАЛЫН НЭГ ЗУУН АРВАН ТАВДУГААР АНГИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/170/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Долгоржав
Утас: 261740 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОХХТҮГ	Онцгой хувцас хэрэглэл туршилт үйлдвэрлэлийн төв
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

Бага тойруу-3, Засгийн газрын IV байр

Утас:26-04-37, Факс:51-26-42-30

E-mail: info@audit.gov.mn

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ХАРЬЯА АР ТАЛЫН 115
ДУГААР АНГИЙН ЗАХИРАГЧ,
ХУРАНДАА Л.БАЯРСАЙХАН ТАНАА

2022.02.25 № 07/378
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ОБЕГ-ын харьяа Ар талын нэг зуун арвантавдугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Ар талын 115 дугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	2,291,109,734.37
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	1,600,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	1,600,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	2,289,509,734.37
351	Түүхий эд материал	0.00	379,227,702.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	364,480,696.00
35130	Эм боох материал	0.00	14,747,006.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.00	1,025,419,363.00
354	Хангамжийн материал	0.00	884,862,669.37
35410	Бичиг хэргийн материал	0.00	675,800.00
35420	Аж ахуйн материал	0.00	857,113,385.93
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	20,369,944.44
35440	Түлш, шатах тослох материал	0.00	3,301,079.00
35450	Барилгын засварын материал	0.00	2,403,300.00
35460	Хүнсний материал	0.00	999,160.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	14,542,681,822.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	14,542,681,822.10
392	Биет хөрөнгө	0.00	14,541,256,405.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	6,163,880,859.36
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(1,095,313,939.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	9,910,206,842.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(471,952,918.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	39,257,738.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(8,222,176.65)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0.00	3,400,000.00
393	Биет бус хөрөнгө	0.00	1,425,416.68
39301	Програм хангамж	0.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(41,250.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	700,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(58,333.32)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	16,833,791,556.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	16,833,791,556.47
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	16,833,791,556.47
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	16,833,791,556.47
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	16,833,791,556.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	16,833,791,556.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	0.00	25,427,957,940.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	22,787,753,140.85
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	22,787,753,140.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	22,787,753,140.85
120006	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	22,787,753,140.85
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	2,640,204,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	2,569,828,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	2,569,828,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	70,376,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	70,376,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	8,551,902,662.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	8,551,902,662.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	8,546,620,397.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	1,687,362,443.50
210101	Үндсэн цалин	0.00	1,025,803,600.00
210102	Нэмэгдэл	0.00	624,201,603.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	37,357,239.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	78,959,196.28
210201	Тэтгэврийн даатгал	0.00	57,959,196.29
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	21,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	186,966,718.00
210401	Бичиг хэрэг	0.00	1,771,300.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	181,111,188.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	1,363,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	2,721,030.00
2105	Нормативт зардал	0.00	4,263,999,066.96
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	13,675,147.96
210502	Хоол, хүнс	0.00	62,584,395.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	4,187,739,524.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1,094,253,104.77
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	585,464,289.00
210604	Урсгал засвар	0.00	508,788,815.77
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	113,017,705.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	72,689,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	2,395,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	24,395,476.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	11,634,729.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	1,408,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	495,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,122,062,162.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,561,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	5,832,965.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	1,114,667,697.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	5,282,264.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	4,700,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	4,700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	582,264.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	582,264.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	0.00	16,876,055,278.47
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	1,561,500.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	0.00	1,561,500.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	43,825,222.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	43,825,222.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	0.00	(42,263,722.00)
5	НИЙТ ҮР ДҮН	0.00	16,833,791,556.47

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээ ний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>0.00</u>	<u>0.00</u>	<u>0.00</u>	<u>0.00</u>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	16,833,791,556.47	16,833,791,556.47
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>0.00</u>	<u>0.00</u>	<u>16,833,791,556.47</u>	<u>16,833,791,556.47</u>

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.00	2,640,204,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	2,640,204,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	2,569,828,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	2,569,828,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	70,376,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	70,376,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	2,509,238,690.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	2,509,238,690.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	2,503,956,425.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	1,694,068,639.78
210101	Үндсэн цалин	0.00	1,025,803,600.00
210102	Нэмэгдэл	0.00	631,807,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	36,457,239.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	70,831,100.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	48,165,148.00
210202	Тэтгэмжийн даатгал		6,666,488.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,133,297.60
210204	Ажилгүйдлийн даатгал		4,533,190.40
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	11,332,976.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	79,469,900.00
210401	Бичиг хэрэг	0.00	2,447,100.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	74,196,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	1,363,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,463,500.00
2105	Нормативт зардал	0.00	68,223,655.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	4,640,100.00
210502	Хоол, хүнс	0.00	63,583,555.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	467,943,250.25
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	23,943,990.00
210604	Урсгал засвар	0.00	443,999,260.25
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	116,852,515.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	74,923,810.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3,995,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	24,395,476.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	11,634,729.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	1,408,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	495,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	6,567,365.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	6,567,365.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	5,282,264.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	4,700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	4,700,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	582,264.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	582,264.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	130,966,110.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	0.00	130,966,110.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	130,966,110.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	130,966,110.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	130,966,110.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	(130,966,110.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,569,828,800.00	2,569,246,535.03	582,264.97	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,569,828,800.00	2,569,246,535.03	582,264.97	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,565,105,400.00	2,564,546,535.03	558,864.97	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,694,213,900.00	1,694,068,639.78	145,260.22	99.9
210101	Үндсэн цалин	1,025,803,600.0	1,025,803,600.00	0.00	100.0
210102	Нэмэгдэл	631,807,800.00	631,807,800.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,602,500.00	36,457,239.78	145,260.22	99.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,831,100.00	70,831,100.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	48,165,000.00	48,165,148.00	(148.00)	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,660,000.00	5,666,488.00	(6,488.00)	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,133,000.00	1,133,297.60	(297.60)	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,530,000.00	4,533,190.40	(3,190.40)	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	21,000,000.00	21,000,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	79,473,800.00	79,469,900.00	3,900.00	100.0
210401	Бичиг хэрэг	2,447,100.00	2,447,100.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	74,200,000.00	74,196,100.00	3,900.00	99.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,363,200.00	1,363,200.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,463,500.00	1,463,500.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	72,400,000.00	72,383,555.00	16,445.00	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,800,000.00	8,800,000.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	63,600,000.00	63,583,555.00	16,445.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	577,361,700.00	577,360,960.25	739.75	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	133,361,700.00	133,361,700.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	444,000,000.00	443,999,260.25	739.75	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,239,500.00	63,865,015.00	374,485.00	99.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,980,000.00	21,936,310.00	43,690.00	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	3,995,500.00	4,500.00	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	24,601,600.00	24,395,476.00	206,124.00	99.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11,699,900.00	11,634,729.00	65,171.00	99.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,463,000.00	1,408,000.00	55,000.00	96.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,000.00	495,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,585,400.00	6,567,365.00	18,035.00	99.7

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,585,400.00	6,567,365.00	18,035.00	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,723,400.00	4,700,000.00	23,400.00	99.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,723,400.00	4,700,000.00	23,400.00	99.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,723,400.00	4,700,000.00	23,400.00	99.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,569,828,800.00	2,569,246,535.03	582,264.97	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,569,828,800.00	2,569,246,535.03	582,264.97	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,569,828,800.00	2,569,246,535.03	582,264.97	99.9
4	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	
5	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	117	117	0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	71	71	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	45	45	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс ны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	70,376,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		70,376,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		70,376,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		70,376,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		70,376,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	70,376,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		70,376,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		70,376,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ОБЕГ-ын харьяа Ар талын нэг зуун арван тавдугаар ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 2-ны хооронд Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Долгоржав гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Сэржмядаг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Ар талын нэг зуун арван тавдугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 43/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ар талын нэг зуун арван тавдугаар анги нь Засгийн газрын 2020 оны 163 дугаар маш нууц тогтоолоор 2021 оны 2 дугаар сард байгуулагдсан Онцгой байдлын ерөнхий газрын харьяа байгууллага юм. Тус байгууллага гамшигийн тусгай зориулалтын техник, хувцас хэрэглэл, тоног төхөөрөмжийн хангалт, засвар үйлчилгээг стандартад заасан техникийн нөхцөл, шаардлагын дагуу зохион байгуулах, ашиглалтад хяналт тавих үндсэн зорилгын хүрээнд 2021 онд

- Албаны техник, багаж, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлийн нөөц бүрдүүлж, чанар, хангалтыг сайжруулах, агуулахын хадгалалтын технологид шинэ стандартыг нэвтрүүлэх;
- Алба хаагчдын ажиллах таатай орчин, эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлж, бие бялдар, биеийн жингийн зохистой харьцааг хангах зэрэг зорилтыг тавин ажиллажээ.

Ар талын нэг зуун арван тавдугаар анги тайлант онд ангийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд штабын байр, албаны авто засварын төв, өдөр тутмын болон ажиллагааны хувцас, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, авто техникийн сэлбэг хэрэгслүүдийг хадгалах агуулахууд зэрэг 2056 м² барилга, байгууламжийг 321.9 мянган төгрөгөөр засварлаж, шалган нэвтрүүлэх байрыг шинээр барьж, албаны тээврийн хэрэгслүүдийн засвар үйлчилгээг гүйцэтгэн гамшигийн бэлэн байдлыг хангаж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага Онцгой байдлын ерөнхий газрын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ар талын нэг зуун арван тавдугаар ангийн үйл ажиллагаанд ОБЕГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар хяналтыг тавих бөгөөд тайлант онд шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ар талын нэг зуун арван тавдугаар ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 8,551,902.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 85,519.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ар талын нэг зуун арван тавдугаар ангийн жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, өр төлбөр, цэвэр өмчийн дүнгийн эхний үлдэгдэл байхгүй байна.

Хүснэгт 1

/төгрөгөөр/

№	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
2	Авлага	0.00	0.00	0.00
3	Урьдчилгаа	0.00	1,600,000.00	(1,600,000.00)
4	Бараа материал	0.00	2,289,509,734.37	(2,289,509,734.37)
5	Үндсэн хөрөнгө	0.00	14,986,637,250.95	(14,986,637,250.95)
6	Нийт хөрөнгийн дүн	0.00	17,277,746,985.32	17,277,746,985.32
7	Өр төлбөр	0.00	0.00	0.00
8	Цэвэр өмч	0.00	17,277,746,985.32	(17,277,746,985.32)
9	Өр төлбөр, цэвэр өмчийн дүн	0.00	17,277,746,985.32	17,277,746,985.32

Дараах дансуудад материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Урьдчилж гарсан зардал данс 1,600.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь Чанарын удирдлагын олон улсын ISO-9001-2015 стандарт тогтоох төлбөрийн урьдчилгааг гаргасантай;
- Тайлант оны эцэст 2,289,509.7 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэйгээр тайлагнажээ. Урсгал санхүүжилтээр 534,822.3 мянга, ОБЕГ, Үндэсний аврах бригад, Гамшиг судлалын хүрээлэн, Улсын нөөцийн 185 дугаар анги зэрэг байгууллагуудаас нийт 7,752,977.1 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлдээ авч, өөрийн үйл ажиллагаанд 852,487.3 мянга, дээд шатны захирагчийн шийдвэрээр төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагуудад 4,605,930.5 мянган төгрөгийн бараа материалыг балансаас балансад шилжүүлэн зарцуулсан;
- Үндсэн хөрөнгийн данс 16,118,270.4 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Урсгал санхүүжилтээс 130,966.1 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, ТӨБЗГ-ын 2021 оны 316 тоот тогтоол, А-1/553, А-1/1990 тоот зөвшөөрлөөр Үндэсний аврах бригад, Давтан сургалт, сэргээн засах төв, Гамшиг судлалын хүрээлэнгээс нийт 16,080,793.3 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн балансад бүртгэж, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/1990 тоот зөвшөөрлөөр 93,489.0 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад салбарын орон нутгийн газруудад шилжүүлсэн байна. Тайлант онд шилжиж ирсэн хөрөнгүүдийн элэгдлийн зардал 670,712.3 мянган төгрөгөөр нэмэгдснээр хуримтлагдсан элэгдэл 1,131,633.2 мянган төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ар талын нэг зуун арван тавдугаар ангийн 2021 оны зарцуулалтыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,569,828.0 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж баталсан ба тайлант онд төсвийг тодотгоогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,569,828.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төсөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилтийг бүрэн авч, арга хэмжээний зардалд 2,569,246.5 мянган төгрөгийг 99.9 хувийн гүйцэтгэлтэй зарцуулж, 582.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Хөтөлбөр	Арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	код	нэр				
70708 Гамшгаас урьдчилан сэргийлэх	80101	Үндсэн үйл ажиллагаа	2,562,125.4	2,561,556.5	558.9	99.9
	80205	Мэдээлэл, сурталчилгаа	2,980.0	2,980.0	0.0	100.0
	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,723.4	4,700.0	23.4	99.5
Дүн			2,569,828.8	2,569,246.5	582.3	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 70,376.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн томилолтод 68,376.0 мянга, ахмад настнуудад 2,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.9 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгадагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд анхаарал татсан асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тус анги албаны техник, багаж, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлийн хангалт, засвар үйлчилгээг стандартад заасан техникийн нөхцөл, шаардлагын дагуу зохион байгуулахын тулд барилга, байгууламж, агуулахыг засварлаж, гамшигийн бэлэн байдлыг ханган ажилласан боловч ангийн үндсэн хөрөнгийн бүртгэлд барилга байгууламж бүртгэгдээгүй байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

Мөн ангийн орон тооны бүтэц нууцад хамааралтай ч тус ангийн бүрэлдэхүүнд Онцгой байдлын ерөнхий газарт ажилладаг үйлчилгээний 29 албан хаагч бүртгэлтэй байгаа нь анхаарал татаж байлаа.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус анги нийт 64 гүйлгээний 944,941.7 мянган төгрөгийн орлого, зарлагаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 40 гүйлгээний 511,928.0 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээг холбогдох тушаал шийдвэр, ажил гүйцэтгэх гэрээнүүдийг хавсарган хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалттай нийцэж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус анги 2021 оны 2 дугаар сард шинээр байгуулагдсан тул өмнөх онд санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар 2021 оны хөрөнгийн тооллогын комиссоос гаргасан үндсэн хөрөнгийн холбогдох шийдвэрийн хэрэгжилт, үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг нягтлан шалгах нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17,900.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрч зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус ангийн ашиглаж буй барилга байгууламжууд нь тус ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлгүй, хөрөнгийг шилжүүлэх холбогдох байгууллагын шийдвэргүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 25 дугаар зүйлийн 25.1, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5,1 дэх заалт, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэн авах саналыг дээд шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн бүртгэл дэх тээврийн хэрэгслүүдээс 14,500.0 мянган төгрөгийн үнэ бүхий Киа Серато маркийн 66-14УНӨ улсын дугаартай шуурхай ажиллагааны автомашин Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газарт; 3,400.0 мянган төгрөгийн өртөгтэй түүх дурсгалт музей нь ОБЕГ-т ашиглагдаж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5,1 дэх заалт, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бусад байгууллагад ашиглагдаж байгаа хөрөнгийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах, эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу данснаас хасах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[illegible]